**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

## Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА -2025/077/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2025 он


Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Г.Сувд

Утас: 99382220 Цахим хаяг: g.suvd2018@gmail.com munkhtuya2220@gmail.com


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/134

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Х.ЭНХСҮРЭН ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,296,854.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 1,113,660.3 мянган төгрөгийг санхүүжилтийг авч 183,194.1 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 104,920.9 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчлийг илрүүлснээс санхүүгийн тайлангийн асуудалтай холбоотой 103,067.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,851.5 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өглөө.

**Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 83.6 хувьтай дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **234,670,719.17** | **381,170,923.78** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 38,354,607.77 | 21,833,234.62 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 38,354,607.77 | 21,833,234.62 |
| **3121** | **Төгрөг** | 38,354,607.77 | 21,833,234.62 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 38,354,607.77 | 21,833,234.62 |
| **33** | **АВЛАГА** | 18,255,692.00 | 183,194,152.62 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 18,255,692.00 | 183,194,152.62 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 178,060,419.40 | 176,143,536.54 |
| **351** | **Түүхий эд материал** | 63,367,609.27 | 43,834,480.15 |
| 35130 | Эм боох материал | 63,367,609.27 | 43,834,480.15 |
| **354** | **Хангамжийн материал** | 114,692,810.13 | 132,309,056.39 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,029,240.00 | 4,591,544.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 18,734,840.31 | 26,878,746.31 |
| 35450 | Барилгын засварын материал | 280,500.00 | 245,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,703,018.00 | 5,637,074.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 83,945,211.82 | 94,956,692.08 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **530,877,158.27** | **560,573,990.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 530,877,158.27 | 560,573,990.20 |
| **392** | **Биет хөрөнгө** | 511,493,408.24 | 541,421,240.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 355,454,680.90 | 352,104,900.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -81,086,459.00 | -98,685,677.84 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 61,276,000.00 | 94,750,999.94 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -35,817,194.26 | -46,917,527.50 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 273,539,409.79 | 298,581,169.79 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -105,625,303.50 | -105,111,268.71 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 72,905,857.36 | 70,871,582.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -29,153,583.05 | -24,172,939.17 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 19,383,750.03 | 19,152,750.03 |
| 39301 | Програм хангамж | 1,155,000.00 | 1,155,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -371,249.97 | -602,249.97 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,600,000.00 | 18,600,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **765,547,877.44** | **941,744,913.98** |
| **413** | **Өглөг** | 1,719,954.00 | 22,111,662.30 |
| **4136** | **Бусад өглөг** | 1,719,954.00 | 22,111,662.30 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,719,954.00 | 22,111,662.30 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **763,827,923.44** | **919,633,251.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 763,827,923.44 | 919,633,251.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 889,082,412.08 | 889,082,412.08 |
| 51101 | Өмч: - төрийн | 889,082,412.08 | 889,082,412.08 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -361,231,023.42 | -24,653,945.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -361,231,023.42 | -180,459,274.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 155,805,328.24 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 235,976,534.78 | 55,204,785.39 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **765,547,877.44** | **941,744,913.98** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,030,159,374.56** | **1,590,841,990.51** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **102,353,554.53** | **222,858,089.90** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 102,353,554.53 | 222,858,089.90 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 47,788,176.00 |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/ | 00.00 | 47,788,176.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө | 67,360,524.50 | 125,151,225.34 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал | 34993030,03 | 49,918,688.56 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **927,805,820.03** | **1,367,983,900.61** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 75,216,100.00 | 89,385,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 75,216,100.00 | 89,385,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 852,504,720.03 | 1,278,598,800.61 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 852,504,720.03 | 1,278,598,800.61 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,114,007,756.20** | **1,435,036,662.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,114,007,756.20** | **1,435,036,662.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,104,047,596.29 | 1,379,589,509.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 697,957,383.76 | 924,244,558.64 |
| 210101 | Үндсэн цалин | 434,787,724.77 | 510,525,898.91 |
| 210102 | Нэмэгдэл | 191,618,909.11 | 300,933,320.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,418,500.00 | 20,941,000.00 |
| 210104 | Урамшуулал | 64,132,249.88 | 91,844,338.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 92,281,500.00 | 107,751,882.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,751,100.00 | 73,256,340.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,382,000.00 | 8,617,881.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,906,000.00 | 4,350,209.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,477,200.00 | 4,304,190.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,765,200.00 | 17,223,262.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 61,498,640.09 | 63,715,823.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,453,860.13 | 4,881,478.22 |
| 210302 | Түлш, халаалт | 50,092,197.96 | 50,385,145.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,952,582.00 | 8,449,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,560,456.16 | 50,218,503.39 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,649,885.00 | 3,891,984.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,317,300.00 | 30,246,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,190,000.00 | 3,040,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 703,640.00 | 435,290.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,849,631.16 | 3,019,320.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,850,000.00 | 9,585,109.39 |
| **2105** | **Нормативт зардал** | 79,262,008.64 | 116,438,584.83 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 71,866,825.64 | 108,587,845.83 |
| 210502 | Хоол, хүнс | 7,395,183.00 | 7,850,739.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,307,500.00 | 14,907,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,105,000.00 | 181,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,202,500.00 | 14,725,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 661,000.00 | 1,110,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 661,000.00 | 1,110,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,261,672.00 | 3,894,550.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,140,000.00 | 2,216,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 81,675.00 | 350,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 205,000.00 | 216,338.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 99,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,712.00 | 96,312.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 829,285.00 | 916,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 111,257,435.64 | 97,308,607.41 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,629,026.00 | 1,854,214.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 103,628,409.64 | 95,454,393.41 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,960,159.91 | 55,447,152.78 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 41,753,176.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 41,753,176.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,960,159.91 | 13,693,976.78 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,960,159.91 | 13,693,976.78 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-83,848,381.64** | **155,805,328.24** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-154,248,381.60** | **155,805,328.24** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **909,550,128.03** | **1,250,833,615.99** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **47,788,176.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 47,788,176.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 47,788,176.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 47,788,176.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **909,550,128.03** | **1,203,045,439.99** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 75,216,100.00 | 89,385,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 75,216,100.00 | 89,385,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 834,249,028.03 | 1,113,660,339.99 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 834,249,028.03 | 1,113,660,339.99 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **983,313,722.76** | **1,267,354,989.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **983,313,722.76** | **1,267,354,989.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **973,353,562.85** | **1,211,907,836.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 697,957,383.76 | 924,244,558.64 |
| 210101 | Үндсэн цалин | 434,787,724.77 | 510,525,898.91 |
| 210102 | Нэмэгдэл | 191,618,909.11 | 300,933,320.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,418,500.00 | 20,941,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 64,132,249.88 | 91,844,338.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 92,281,500.00 | 107,751,882.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,751,100.00 | 73,256,340.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,382,000.00 | 8,617,881.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,906,000.00 | 4,350,209.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,477,200.00 | 4,304,190.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,765,200.00 | 17,223,262.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 61,498,640.09 | 63,715,823.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,137,189.12 | 4,881,478.22 |
| 210302 | Түлш, халаалт | 50,408,868.97 | 50,385,145.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,952,582.00 | 8,449,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 36,186,919.00 | 37,618,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,779,350.00 | 2,881,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,387,700.00 | 29,390,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,190,000.00 | 3,040,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,164,869.00 | 656,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,665,000.00 | 1,650,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 57,448,700.00 | 47,925,909.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,356,300.00 | 37,520,309.50 |
| 210502 | Хоол, хүнс | 9,100,400.00 | 6,205,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,992,000.00 | 4,200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,579,900.00 | 17,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,414,500.00 | 17,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 661,000.00 | 1,110,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 661,000.00 | 1,110,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,536,037.00 | 4,092,250.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,220,000.00 | 2,216,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 81,675.00 | 350,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 205,000.00 | 216,338.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 99,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,712.00 | 96,312.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,023,650.00 | 1,114,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,203,483.00 | 7,848,863.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,203,483.00 | 7,848,863.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,960,159.91** | **55,447,152.78** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 41,753,176.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 41,753,176.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,960,159.91 | 13,693,976.78 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,960,159.91 | 13,693,976.78 |

| | | | |
|---|---|---|---|
| | | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | -73,763,594.73 | -16,521,373.15 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -92,812,494.73 | -16,521,373.15 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 131,167,102.50 | 38,354,607.77 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 38,354,607.77 | 21,833,234.62 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **889,082,412.08** | **235,976,534.78** | **-361,231,023.42** | 763,827,923.44 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **889,082,412.08** | **235,976,534.78** | **-361,231,023.42** | 763,827,923.44 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 180,771,749.39 | 180,771,749.39 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **889,082,412.08** | **235,976,534.78** | **-180,459,274.03** | 944,599,672.83 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -180,771,749.39 | 00.00 | -180,771,749.39 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 155,805,328.24 | 155,805,328.24 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **889,082,412.08** | **55,204,785.39** | **-24,653,945.79** | 919,633,251.68 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Улсын төсөв

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,262,526,700.00 | 1,177,969,889.14 | 84,556,810.86 | 93.3 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,262,526,700.00 | 1,177,969,889.14 | 84,556,810.86 | 93.3 |
| Бараа, үйлчилгээний зардал | 1,182,526,700.00 | 1,136,216,713.14 | 46,309,986.86 | 96.1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 957,136,200.00 | 924,244,558.64 | 32,891,641.36 | 96.6 |
| Үндсэн цалин | 543,959,800.00 | 510,525,898.91 | 33,433,901.09 | 93.9 |
| Нэмэгдэл | 306,315,000.00 | 300,933,320.85 | 5,381,679.15 | 98.2 |
| Унаа, болон бусад нөхөн олговор | 10,440,000.00 | 20,941,000.00 | (10,501,000.00) | 200.6 |
| Урамшуулал | 96,421,400.00 | 91,844,338.88 | 4,577,061.12 | 95.3 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 116,037,500.00 | 107,751,882.00 | 8,285,618.00 | 92.9 |
| Тэтгэврийн даатгал | 78,935,100.00 | 73,256,340.00 | 5,678,760.00 | 92.8 |
| Тэтгэмжийн даатгал | 9,286,300.00 | 8,617,881.00 | 668,419.00 | 92.8 |
| ҮОМШӨ ний даатгал | 4,602,200.00 | 4,350,209.00 | 251,991.00 | 94.5 |
| Ажилгүйдлийн даатгал | 4,641,200.00 | 4,304,190.00 | 337,010.00 | 92.7 |
| Эрүүл мэндийн даатгал | 18,572,700.00 | 17,223,262.00 | 1,349,438.00 | 92.7 |
| Хангамж, бараа материалын зардал | 38,345,200.00 | 37,618,550.00 | 726,650.00 | 98.1 |
| Бичиг хэрэг | 3,257,200.00 | 2,881,500.00 | 375,700.00 | 88.5 |
| Тээвэр (шатахуун) | 29,390,200.00 | 29,390,200.00 | - | 100.0 |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 2,869,500.00 | 3,040,000.00 | (170,500.00) | 105.9 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,163,300.00 | 656,400.00 | 506,900.00 | 56.4 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 1,665,000.00 | 1,650,450.00 | 14,550.00 | 99.1 |
| Нормативт зардал | 48,036,600.00 | 47,925,909.50 | 110,690.50 | 99.8 |
| Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | 35,751,100.00 | 37,520,309.50 | (1,769,209.50) | 104.9 |
| Хоол, хүнс | 8,085,500.00 | 6,205,600.00 | 1,879,900.00 | 76.7 |
| Нормын хувцас зөөлөн эдлэл | 4,200,000.00 | 4,200,000.00 | - | 100.0 |
| Эд хогшил худалдан авах | 5,624,700.00 | 5,624,700.00 | - | 100.0 |
| Урсгал засвар | 5,624,700.00 | 5,624,700.00 | - | 100.0 |
| Томилолт, зочны зардал | 1,350,000.00 | 1,110,000.00 | 240,000.00 | 82.2 |
| Дотоод албан томилолт | 1,350,000.00 | 1,110,000.00 | 240,000.00 | 82.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 4,720,700.00 | 4,092,250.00 | 628,450.00 | 86.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,350,400.00 | 2,216,300.00 | 134,100.00 | 94.3 |
| Даатгалын үйлчилгээ | 350,000.00 | 350,000.00 | - | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 225,000.00 | 216,338.00 | 8,662.00 | 96.2 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 | - | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Газрын төлбөр | 380,000.00 | 96,312.00 | 283,688.00 | 25.3 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,316,300.00 | 1,114,300.00 | 202,000.00 | 84.7 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 11,275,800.00 | 7,848,863.00 | 3,426,937.00 | 69.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 11,275,800.00 | 7,848,863.00 | 3,426,937.00 | 69.6 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 80,000,000.00 | 41,753,176.00 | 38,246,824.00 | 52.2 |
| Бусад урсгал шилжүүлэг | 80,000,000.00 | 41,753,176.00 | 38,246,824.00 | 52.2 |
| Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 80,000,000.00 | 41,753,176.00 | 38,246,824.00 | 52.2 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,262,526,700.00 | 1,161,448,515.99 | 101,078,184.01 | 92.0 |
| НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,152,026,700.00 | 1,113,660,339.99 | 38,366,360.01 | 96.7 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,152,026,700.00 | 1,113,660,339.99 | 38,366,360.01 | 96.7 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 110,500,000.00 | 47,788,176.00 | 62,711,824.00 | 43.2 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 110,500,000.00 | 47,788,176.00 | 62,711,824.00 | 43.2 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 38,354,607.77 | | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 21,833,234.62 | | - |

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 89,385,100.00 | 75,691,123.22 | 13,693,976.78 | 84.68 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 89,385,100.00 | 75,691,123.22 | 13,693,976.78 | 84.68 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 89,385,100.00 | 75,691,123.22 | 13,693,976.78 | 84.68 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 77,385,100.00 | 63,715,823.22 | 13,669,276.78 | 82.34 |
| 18 | Гэрэл цахилгаан | 5,560,900.00 | 4,881,478.22 | 679,421.78 | 87.78 |
| 19 | Түлш, халаалт | 62,404,900.00 | 50,385,145.00 | 12,019,755.00 | 80.74 |
| 20 | Цэвэр, бохир ус | 9,419,300.00 | 8,449,200.00 | 970,100.00 | 89.70 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 12,000,000.00 | 11,975,300.00 | 24,700.00 | 99.79 |
| 38 | Урсгал засвар | 12,000,000.00 | 11,975,300.00 | 24,700.00 | 99.79 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 89,385,100.00 | 75,691,123.22 | 13,693,976.78 | 84.68 |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 89,385,100.00 | 75,691,123.22 | 13,693,976.78 | 84.68 |
| 104 | Орон нутгийн төсвөөс | 89,385,100.00 | 75,691,123.22 | 13,693,976.78 | 84.68 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 104,920.9 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрсэн. Илрүүлсэн 2 алдааг залруулж 5 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,851.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 17,824.1 мянган төгрөгөөс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

**Залруулсан алдаа:**

- Бараа материалын тодруулга тайланд Эрүүл мэндийн газраас ирүүлсэн 49,918.7 мянган төгрөгийн эм, хэрэгсэл, аж ахуйн материалыг хандив, шилжүүлэн авснаар бүртгэсэн, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуваарилагдан ирсэн 53,150.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжийг худалдан авснаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "*үнэн зөв байх*;" заалттай нийцэхгүй "*үнэлгээ ба хуваарилал*" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул эрүүл мэндийн даатгалаас санхүүжих санхүүжилтийн дүнгээр бүртгүүлж залруулга хийсэн.

**Зөвлөмж :** Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт*:

Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "*Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.*" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

*Илрүүлэлт:*

Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд сумын иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний санхүүжилт 1,305,608.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 27,009.4 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;", Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолын 3.1 "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,.." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим

системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах **Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт*</u>

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 35 гүйлгээнээс хугацаа хоцроосон 32 , мэдээлээгүй 3 гүйлгээ, зарлагын 16 гүйлгээнээс хугацаанд нь мэдээлсэн 1 , хугацаа хоцроосон 7, мэдээлээгүй 8 гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг 2 удаа, төсвийн төсөл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн нь "Шилэн дансны тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*;" заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*;" 6.4.8 "*бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;*" заалт болон "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u>

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Ахмадын сангийн талаар**

<u>*Илрүүлэлт:*</u>

Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "*Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах…*" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u>

Байгууллагын цалингийн сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр Ахмадын сан байгуулах хөрөнгийг төсөвт тусган хэрэгжүүлэх

**Эмийн үлдэгдлийн талаар**

<u>*Илрүүлэлт*</u>

Бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 1,851,5 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь бараа материалын үлдэгдлийг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг тууштай мөрдөөгүй болон тухайн эмийг зарцуулах өвчлөлийн тохиолдол гараагүй зэргээс шалтгаалсан байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>

Эмийн үлдэгдэл,хэрэгцээ шаардлагыг бодитоор тооцон эмийн захиалгыг өгч,материалын үлдэгдлийг эхэлж авснаа, эхэлж зарлагдах, эмийн хадгалалтын хугацаанд байнга хяналт хийж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч байх.

## 2. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын тодруулга тайланд Эрүүл мэндийн газраас ирүүлсэн эм, хэрэгсэл, аж ахуйн материалыг хандив, шилжүүлэн авснаар бүртгэсэн. | 1 | 49,918.7 | | | | 49,918.7 | | 49,918.7 | | |
| Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуваарилагдан ирсэн тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжийг худалдан авснаар бүртгэсэн | 1 | 53,150.8 | | | | 53,150.8 | | 53,150.8 | | |
| Дүн | **1** | **103,069.5** | | | | **103,069.5** | | **103,069.5** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын үйл ажиллагааны онцлогт | 1 | - | | | | | 1 | |
| тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шилэн дансны цахим хуудсанд 39 мэдээллийг хугацаа хоцроож 11 мэдээллийг оруулаагүй | 1 | - | | | | - | 1 | |
| Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэ зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй. | **1** | | | | | | 1 | |
| Бараа материалын үлдэгдэлд жилийн турш хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн эмийн үлдэгдэлтэй байна. | 1 | **1,851.5** | | | | | 1 | 1,851.5 |
| Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй байна. | **1** | - | | | | | 1 | |
| Дүн | **5** | **1,851.5** | | | | **-** | 5 | 1,851.5 |

**3. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | 1 | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | **1** | | **1** | | | |